

УЛААНБААТАР ХОТ  
БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ



БАТЛАВ  
МӨНХ ОЮУТ ОРГИЛ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Б.СУВДАА



АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № 67/2022

20... оны ...-р сарын ...

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Мөнх оюут оргил ХХК-ийг төлөөлж захирал Б.Сувдаа /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

### Нэг. Гэрээгээр гүйцэтгэх зүйл, нөхцөл

1.1 Гүйцэтгэгч нь “Ариутгал, халдваргүйжүүлэлт” (цаашид “ажил” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтанд заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-д гүйцэтгэнэ.

#### Хоёр. Ажил гүйцэтгэх хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 14 хоног тутамд 1 удаа нийт 10 удаа бүх өрөө тасалгаанд ариутгал халдваргүйжүүлэлт хийж сар бүр тайлан гаргана.

#### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Гэрээний нийт үнэ 3,000,000 /Гурван сая/ төгрөг бөгөөд үнийн дүнд НӨАТ болон бусад татвар хураамж багтсан.

3.2 Гэрээ баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор төлбөрийг гүйцэтгэгчийн Хаан банкны 5023802661 тоот дансанд нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

#### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд нийт үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2 Захиалагч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа төлбөрөө шилжүүлээгүй тохиолдолд нийт үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид хоног тутам төлөх ба нийт алдангийн дүн гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.

4.3 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Аж ахуйн ажилтан Д.Бямбадорж хариуцан ажиллана. Утас-80286247

4.4 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Мөнх оюут оргил ХХК-ийн захирал Б.Сувдаа хариуцан ажиллана. Утас-99706092.

#### Тав. Давагдашгүй хүчин зүйл

5.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж

гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.

- 5.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 10 хоногийн дотор талууд бие биедээ бичигээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

### Зургаа. Гэрээг цуцлах үндэслэл

- 6.1 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэлгүй энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгнө. Гүйцэтгэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлана.
- 6.2 Гүйцэтгэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Долоо. Бусад нөхцөл

- 7.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбоотой мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 7.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 7.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Гүйцэтгэгч тал 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 7.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 7.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 7.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 7.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

Ө.УДВАЛ  
Гарын үсэг:



ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг:



ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г.САРУУЛ

Гарын үсэг:



ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ш.ГАНТУЛГА

Гарын үсэг:



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: МӨНХ ОЮУТ ОРГИЛ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Б.СУВДАА

Гарын үсэг:



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,  
БГД 12-р хороо 13-р байр 112 тоот  
Утас: 99706092  
РД: 6698883

6/2/2022 Тоот гэрээний хавсралт

Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх хуваарь

д/д	Ажлын нэр	Хэмжих нэгж, хоног	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ /НӨАТ-тай/
1	Ариутгал, Халдваргүйжүүлэлтийн ажил	14 хоногт нэг удаа	10	300,000	3,000,000

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Аж ахуйн ажилтан

*D. Бямбадорж*

Д.Бямбадорж

Мөнх оюут оргил ХХК-ийн захирал

*Б.Сувдаа*

Б.Сувдаа